



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 02 сарын 26 өдөр

Дугаар А/152

Булган сум

Гавьяатуудад хүндэтгэл үзүүлэх,
“Бид Булганчууд” сар шинийн их золголтын
хэвлэл мэдээлэл, зар сурталчилгааны зардалд
хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6 дахь заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны “Булганы сэргэлт хөтөлбөрийг батлах тухай” IV/25 дугаар тогтоол, 2025 оны XII хуралдааны “Булган аймгийн 2026 оны төсөв батлах тухай” XII/90 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Бид Булганчууд” сар шинийн их золголтын хэвлэл мэдээлэл, зар сурталчилгааны зардалыг хавсралтаар баталсугай.

2.Булган сумын уугуул, төрийн албаны ахмад ажилтан Ц.Лхагвасүрэн “Хөдөө аж ахуйн гавьяат ажилтан”, аймгийн Эрүүл мэндийн газрын дарга асан С.Нарантуяа “Эрүүлийг хамгаалахын гавьяат ажилтан”, Тэшиг сумын уугуул чөлөөт бөхийн үндэсний шигшээ багийн тамирчин Т.Түвшинтулга, Хишиг-Өндөр сумын уугуул, буудлага спортын тамирчин З.Батхуяг нар гавьяат тамирчин хэмээх Төрийн дээд шагналаар шагнагдсан тул тус бүр 1,000,000 (нэг сая) төгрөгийн хүндэтгэл үзүүлсүгэй.

3.Дээрх үйл ажиллагаанд шаардагдах 3,731,500 (гурван сая долоон зуун гучин нэгэн мянга таван зуу) төгрөгийг “Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх” хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардал, гавьяатуудад хүндэтгэл үзүүлэх, лам ном хурахад шаардагдах 4,800,000 (дөрвөн сая найман зуун мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөцийн хөрөнгөөс санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

6326010198

02
A/12
Аймгийн Засаг даргын 2026 оны
дугаар сарын 20-ныгний өдрийн
дугаар захирамжийн хавсралт

Зохион байгуулалтын зардалд шаардагдах төсөв

Д/д	Зардлын нэр	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт дүн
1	2	3	4	5
Хэвлэл мэдээлэл, зар сурталчилгааны зардал				
1	Урилга хэвлэлийн зардал	70ш	6,000	420,000
2	Мандат / ажилтан, алба хаагчид/	150ш	2,000	300,000
3	Туг өлгөх /16 сум 1 тосгон болон аймгийн туг төрийн далбаа/	19ш	20,000	380,000
4	Стент хэвлэл	5ш	45,000	225,000
5	Үүдний хоёр модон рам	368x206	18,000	136,500
6	Гадна талд байрлуулах хулдаасан хэвлэл	5мx3м	18,000	270,000
7	Зар сурталчилгааны зардал / Сайт, Телевиз/	2	1,000,000	2,000,000
Нийт дүн			3,731,500	
Бусад				
1	Лам ном хурах зардал	4	200,000	800,000
2	Гавьяатууд хүндэтгэл үзүүлэх	4	1,000,000	4,000,000
Нийт дүн			4,800,000	
Бүгд дүн			8,531,500	

--o0o--